МЭДЭЭ · 2022 оны 12-р сарын 15

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР "ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА" ЦОМООР ШАГНУУЛЖЭЭ



Дорноговь аймгийн прокурорын газар тус Аймгийн Засаг даргын Тамгын газраас жил бүрийн Олон улсын Хүний эрхийн өдрөөр хүний эрхийг хамгаалагч төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд зохион байгуулдаг "Хүний эрхийн төлөө хамтдаа" уулзалтад оролцлоо.

Тус уулзалтад хүний эрхийг хамгаалагч нийт 50 гаруй байгууллагын төлөөллүүд оролцож, хүний эрхийг хангах чиглэлээр 2022 онд хийсэн ажлынхаа талаар мэдээлэл солилцон, хамгийн үр дүнтэй ажил хэрэгжүүлсэн байгууллагыг шалгаруулсан байна.

Тодруулбал, төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, шуурхай хүргэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлогт тохирсон үйлчилгээг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн Дорноговь аймгийн прокурорын газар шилдгээр шалгарч, "ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА" цомыг авсан байна.

Видео: https://www.youtube.com/watch?v=Ur1oN5mewhI

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2062